



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/1/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН ТЕЗ-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	9
3. АУДИТЫН ТАЙЛАН	11
3.1. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	11
3.1.1. Аудит хийсэн үндэслэл.....	11
3.1.2. Аудитын зорилт, хамарсан хүрээ	11
3.1.3. Аудитын арга зүй.....	11
3.1.4. Материаллаг байдлын түвшин	11
3.2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	12
3.2.1. Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж	12
3.2.2. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн	12
3.3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	13
3.3.1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	13
3.3.2. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	13
3.3.3. Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	13
3.3.4. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	13
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4.1. Мөнгөн хөрөнгө	14
4.2. Авлага	15
4.3. Урьдчилгаа	16
4.4. Бараа материал.....	17
4.5. Нөөцийн бараа.....	17
4.6. Бусад эргэлтийн хөрөнгө.....	18
4.7. Үндсэн хөрөнгө.....	18
4.8. Өр төлбөр	20
4.9. Засгийн газрын хувь оролцоо	21
4.10. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит.....	22
4.11. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА	22
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл	24
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	25
6.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	26
6.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуйн нэгж
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ДОНЗТ	Дархан орон нутгийн зам тээвэр
ДХББЗГ	Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар
ДХСАХ	Дархан хотын соёл амралтын хүрээлэн
ДХТҮГ	Дархан хотын тохижилт үйлчилгээний газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.АЗЖАРГАЛ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.16

№ 202

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл” 2016 оны 3 дугаар сард эхлэн, тайлант онд дууссанаар 39,559.2 сая төгрөгийн хөрөнгийг “Дархан Ус суваг” ОНӨХК-д бүртгэсэн ба үүнээс 27,885.5 сая төгрөгийг Сангийн яам буюу Засгийн газарт төлж барагдуулснаар үлдэгдэл 11,703.7 сая төгрөгийг ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 29,115.4 сая төгрөгийн, төслийн хөрөнгөөр санхүүжсэн 39,559.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж, тайланд толилуулж, тодруулсан байна.

4525020320

Бусад асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 66 зорилтын хүрээнд 318 арга хэмжээ баталж, хэрэгжүүлснийг Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс 96.22 хувиар үнэлж, аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 35 дугаар тогтоолоор "Хангалттай" гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН ТЕЗ-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,340,405.6	57,519,222.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	55,197,184.0	49,300,419.4
33	АВЛАГА	2,769,608.8	2,700,735.6
34	УРЬДЧИЛГАА	75,724.8	446,865.7
35	БАРАА МАТЕРИАЛ	3,789,821.4	4,630,666.6
36	НӨӨЦИЙН БАРАА	147,975.5	169,070.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	8,360,091.1	271,464.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	213,087,288.8	283,121,520.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	213,087,288.8	283,121,520.7
39200	Биет хөрөнгө	164,731,089.8	230,025,160.1
39300	Биет бус хөрөнгө	48,354,599.0	53,094,760.6
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,600.0	1,600.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	283,427,694.4	340,640,743.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	81,281,956.5	64,780,365.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	81,281,956.5	53,076,667.6
41200	Богино хугацаат зээлийн өглөг	51,890,351.3	31,086,579.5
41300	Өглөг	29,381,635.3	21,978,751.8
41400	Урьдчилж орсон орлого	9,969.9	11,336.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	11,703,697.8
42200	Урт хугацаат зээл	-	11,703,697.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	202,145,737.8	275,860,378.0
51	Засгийн газрын хувь оролцоо	202,145,737.8	275,860,378.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	22,834,922.3	18,931,779.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,187,455.1	5,242,763.9
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	168,853,230.3	219,215,722.7
51200	Хуримтлагдсан үр дүн	(46,782,630.8)	(1,582,649.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,052,760.9	34,052,760.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	283,427,694.4	340,640,743.3

ХТ05430@9022699

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	180,023,662.8	155,575,926.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	48,510,009.5	73,583,368.9
110	Орлогын албан татвар	39,277,067.7	62,466,873.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,547,869.1	57,483,625.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,558,587.9)	(3,345,948.9)
1103	ААН-ын орлогын албан татвар	5,287,786.5	8,329,197.0
113	Хөрөнгийн албан татвар	3,853,685.0	4,060,346.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,379,256.8	7,056,148.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,624,260.0	73,949,664.4
120	Нийтлэг татварын бус орлого	15,261,526.6	53,926,003.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	13,362,733.4	20,023,660.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	102,889,393.3	8,042,893.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	60,352,502.1	82,266,130.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,352,502.1	82,266,130.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,358,409.0	72,592,990.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,944,703.9	25,077,999.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,397,014.7	3,172,995.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,654,644.0	7,687,496.6
2104	Хангамж, бараа материалын зардал	2,050,695.3	2,003,055.1
2105	Нормативт зардал	536,774.5	694,525.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,640,663.8	2,657,254.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,021,214.9	5,987,097.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,940,330.3	25,075,880.0
212	ТАТААС	984,737.6	3,120,388.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,009,355.5	6,552,751.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	119,671,160.7	73,309,795.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	118,714,762.4	28,084,346.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	956,398.3	45,225,449.0

ХТ05430 @ 9022899

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,715,057.9	-	184,715,057.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(6,526.2)	-	(6,526.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,708,531.7	-	184,708,531.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	11,734,254.3	-	11,734,254.3
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	4,881,560.4	-	4,881,560.4
8	Зарласан ногдол ашиг	(135,006.9)	-	(135,006.9)
9	Тайлант үеийн үр дүн	956,398.3	-	956,398.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,145,737.8	-	202,145,737.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	202,145,737.8	-	202,145,737.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	68,616.5	-	68,616.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,214,354.3	-	202,214,354.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	13,422,943.9	-	13,422,943.9
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	15,091,714.8	-	15,091,714.8
18	Зарласан ногдол ашиг	(94,084.0)	-	(94,084.0)
19	Тайлант үеийн үр дүн	45,225,449.0	-	45,225,449.0
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,860,378.0	-	275,860,378.0

ХТӨ5430@5012899

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	210,543,259.5	141,370,279.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	43,310,009.1	72,084,649.7
110	Орлогын албан татвар	34,077,067.3	62,466,873.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,547,869.1	57,483,625.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,558,587.9)	(3,345,948.9)
1103	ААН-ын орлогын албан татвар	87,786.2	8,329,197.0
113	Хөрөнгийн албан татвар	3,853,685.0	4,060,346.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,379,256.8	5,557,429.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	673,835.1	906,003.8
1181	Газрын төлбөр	4,171,797.6	3,186,791.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	533,624.2	1,464,634.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,903,922.9	62,375,671.4
120	Нийтлэг татварын бус орлого	51,541,189.5	42,352,010.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	13,362,733.4	20,023,660.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	102,329,327.5	6,909,958.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,275,625.1	117,638,927.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,275,625.1	117,638,927.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,034,465.2	86,492,668.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,154,411.9	27,603,770.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,445,932.1	4,351,783.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,610,284.1	8,102,346.5
2104	Хангамж, бараа материалын зардал	7,737,444.8	8,045,438.5
2105	Нормативт зардал	453,256.2	458,085.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,208,683.8	2,505,750.3
2107	Томилолт, зочны зардал	134,235.5	206,141.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,026,775.2	6,752,752.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,263,441.6	28,466,600.3
211	ХҮҮ	-	21,850,000.0
212	ТАТААС	986,867.7	2,856,844.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,254,292.2	6,439,414.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	155,267,634.4	23,731,351.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	7,274.7	10,170.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	118,314,363.5	29,431,387.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,314,363.5	29,431,387.5
2200	Дотоод эх үүсвэрээр	115,064,692.4	26,918,310.3
2260	Гадаад эх үүсвэрээр	3,249,671.0	2,513,077.1

ХТ05430@3017355

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(118,307,088.8)	(29,421,217.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(958,735.9)	(206,899.4)
14	Бусад эх үүсвэр	200,000.0	630,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	838,840.0	58,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	319,895.9	778,899.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	36,001,809.7	(5,896,764.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,195,374.3	55,197,184.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,197,184.0	49,300,419.4

ХТ05430 @ 9922899

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1. Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар аймгийн ИТХ-ыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3. Аудитын арга зүй

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон горим сорил гүйцэтгэж, үнэлгээ өгөв.

3.1.4. Материаллаг байдлын түвшин

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Өмнөх онд илэрсэн алдаа, зөрчлийн дийлэнх нь санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлтүүдээс илэрсэн тул нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон болно.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сонгосон суурь үзүүлэлт 341,049.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,410.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,387.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгээр суурь үзүүлэлтийг тодорхойлсон тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Дархан-Уул аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2¹ дахь заалтын дагуу ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 1-10/153 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын хоорондын өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан дүнг 30,758.9 сая төгрөгөөр санхүүгийн байдлын тайланд, 159,532.1 сая төгрөгөөр санхүүгийн үр дүнгийн тайланд, 168,262.9 сая төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайланд тус тус устгах бичилт хийсэн,
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 18 төсөвт байгууллага, гүйцэтгэл үр дүнгээр санхүүждэг 61 байгууллага /орон нутгийн төсвөөс санхүүжих байр ашиглалтын зардал/, 1 төсөл сан, 1 орон нутгийн хөрөнгө оруулалт, 10 орон нутгийн тусгай сан, 20 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, нийт 111 санхүүгийн тайлан болон ерөнхий орлого, засаг дарга, байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцааны 13 дансны гүйлгээг нэгтгэсэн байна.

3.2.1. Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт “төгрөг”-өөр илэрхийлжээ.

3.2.2. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	НББ-ийн бодлого, зарчим
ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
ТЕЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	
ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна

3.3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 20.2 хувиар буюу 57,213.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өөрчлөлт
Эргэлтийн хөрөнгө	70,340.4	57,519.2	(12,821.2)
Эргэлтийн бус хөрөнгө	213,087.3	283,121.5	70,034.2
Нийт хөрөнгийн дүн	283,427.7	340,640.7	57,213.0
Нийт өр төлбөр	81,282.0	64,780.3	(16,501.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	202,145.7	275,860.4	73,714.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	283,427.7	340,640.7	57,213.0

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл” дууссанаар бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлсэн, уг зээлийн өрөнд 21,850.0 сая төгрөгийг төлсөнтэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгө буурчээ.

Харин орон нутгийн хөгжлийн сан, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт өссөнөөр хөрөнгө бий болж, үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

3.3.2. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар 155,575.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 110,350.5 сая төгрөгийн зардал гаргаснаар тайлант онд үйл ажиллагааны нийт үр дүн 45,225.4 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

3.3.3. Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар өмчийн дүн 28,514.7 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 45,200.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.3.4. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн 2024 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлогыг 142,010.4 сая төгрөг, мөнгөн зарлагыг 147,907.2 сая төгрөгөөр илэрхийлснээр мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 5,896.8 сая төгрөгөөр буурсан байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 49,300.4 сая төгрөг болж, өмнөх оноос 5,896.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	55,197.2	49,300.4	(5,896.8)
Төгрөг	53,351.1	47,601.6	(5,749.5)
Гадаад валют	1,846.1	1,698.8	(147.3)
Дүн	55,197.2	49,300.4	(5,896.8)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	32,174.7	25,995.1	(6,179.6)
Төсөл/сан	1,948.4	1,837.6	(110.8)
Төрийн сан	19,677.3	18,584.3	(1,093.0)
ОНӨҮГ	1,396.8	2,883.4	1,486.6
Дүн	55,197.2	49,300.4	(5,896.8)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн 5,896.8 сая төгрөгийн бууралт нь Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн зээлийн өрөнд 21,850.0 сая төгрөгийг төлсөнтэй холбоотой байна.

Банканд байршиж буй 49,300.4 сая төгрөгийн 47,601.6 сая төгрөг нь үндэсний мөнгөн тэмдэгтээр, 1,698.8 сая төгрөг нь гадаад валютаарх үлдэгдэл байна.

Гадаад валютын үлдэгдэл 1,698.8 сая төгрөг нь Европын холбооны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Найрамдал-Дархан хотын нийгэм, эдийн засгийн шинэлэг, тэгш хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжин Европын холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх төсөл”-ийн харилцах дансны үлдэгдэл байна. Энэхүү төсөл нь аймгийн ЗДТГ, ХААИС-ийн харьяа Дархан салбар сургууль хамтран Европын холбооноос зарласан “Орон нутгийн засаглал, тогтвортой хотуудын түншлэл 2021 төсөл”-д орон нутгийн цахим засаглалыг бэхжүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, инноваци технологид суурилсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилготой, нийт 3.0 сая еврогийн санхүүжилттэй төсөл юм.

Харин төгрөгийн үлдэгдэл 47,601.6 сая төгрөгийн 25,995.1 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 138.8 сая төгрөг нь сумдын байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн, 18,584.3 сая төгрөг нь аймаг, сумдын ерөнхий орлогын, 2,883.4 сая төгрөг нь орон нутгийн өмчит байгууллагын үлдэгдэл байна.

Төсөвт байгууллагад бүртгэгдсэн 25,995.1 сая төгрөгийн 19,656.3 сая төгрөг нь орон нутгийн хөрөнгө оруулалтын, 5,363.7 сая төгрөг нь ОНХС-ийн, 975.1 сая төгрөг нь ХХС-ийн үлдэгдэл байна.

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 49,300.4 сая төгрөгийн 90.7 хувь буюу 44,718.2 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 9.3 хувь буюу 4,582.2 сая төгрөг нь арилжааны банканд байршсан байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 19,677.3 сая төгрөг, оны эцэст үлдэгдэл 18,584.3 сая төгрөг болж, 1,093.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	19,677.3	18,584.3	(1,093.0)
Төгрөг	19,677.3	18,584.3	(1,093.0)
Төрийн сан	19,677.3	18,584.3	(1,093.0)
Нийт дүн	19,677.3	18,584.3	(1,093.0)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогоор 79,007.9 сая төгрөгийг бүрдүүлэн, оны эцэст зарцуулаагүй үлдсэн 6,787.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 63,160.5 сая төгрөгийг харьяа байгууллагуудын санхүүжилтэд, 522.5 сая төгрөгийг өмнөх оны татаас санхүүжилтийн өглөгт, 21,850.0 сая төгрөгийг дамжуулан зээлийн өрөнд, 1,355.1 сая төгрөгийг аймгийн төсвөөс улсын төсөвт татан төвлөрүүлэх шилжүүлэгт зарцуулжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудаас ахмадын сангийн судалгааг гаргуулан авч, хянан үзэхэд ахмадын санд нийт 30.3 сая төгрөг төвлөрүүлснээс 21.3 сая төгрөгийг цагаан сар болон ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэхэд зарцуулсан байна. Аудитаар сангийн зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй, харин 10 байгууллага ахмадын сан байгуулаагүйд зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Дархан сумын ЗДТГ мөнгөн гүйлгээний тайланд 355.7 сая төгрөгийн тайлант оны төвлөрүүлэх шилжүүлгийг тусгаагүй.
- Худалдан авах ажиллагааны газар төсвийн хөрөнгөөр худалдан авсан 61.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ хэсэгт илэрхийлээгүй.
- Захирагчийн ажлын алба 44.6 сая төгрөгийн хийгдээгүй ажлыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн, тайлант үеийн үр дүн 67.9 сая төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайланд тусгаагүй.
- Аймгийн ЗДТГ 11.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгосон.
- Дархан сумын ИТХ санхүүгийн ажилтнуудад 2.0 сая төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон.
- Дархан сумын ХХС сангийн хөрөнгөөр 1.6 сая төгрөгийн скайнер худалдан авсан.
- “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар 7.5 сая төгрөгийн зардал гаргасан.
- Хонгор сумын ЗДТГ 1.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү олгосон, 3.1 сая төгрөгийн шатахууны урамшууллыг санхүүгийн тайланд бүртгээгүй, санхүүгийн ажилтнуудад 3.0 сая төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон.
- Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-ын 4.6 сая төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтагүй.
- Орхон сумын ЗДТГ тушаал шийдвэргүйгээр 1.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, тэмцээн уралдаанд оролцох тамирчдад 2.7 сая төгрөгийн дэмжлэг олгосон.
- Шарын гол сумын ЗДТГ үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 4.4 сая төгрөгийн балансын урамшуулал олгосон, 10.0 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу, 3.2 сая төгрөгийн өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тайлагнасан.
- Шарын гол сумын ИТХ 3.0 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй.
- “Тулга сувилал” ОНӨААТҮГ зах зээлийн үнээс 1.9 сая төгрөгөөр илүү үнээр бараа материал бэлтгэсэн, тодруулга тайланд 481.5 сая төгрөгийн зардлыг бөөн дүнгээр бичсэн.

4.2. Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,667.1 сая төгрөг болж, өмнөх оноос 102.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	243.7	2.7	(241.0)
Төлбөртэй үйлчилгээний авлага	6.8	394.3	387.5
Зээлийн хүүгийн авлага	13.6	11.9	(1.7)
Дансны авлага /ОНӨҮГ/	568.3	1,037.5	469.2
Татвар, НДШ-ийн авлага /ОНӨҮГ/	17.6	7.6	(10.0)
Байгууллагаас авах авлага	247.9	64.3	(183.6)
Хувь хүмүүсээс авах авлага	1,671.7	1,182.4	(489.3)
Дүн	2,769.6	2,700.7	(68.9)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,666.6	1,226.4	(440.2)
Төрийн сан	33.6	33.6	0.0
ОНӨҮГ	1,069.4	1,440.7	371.3
Дүн	2,769.6	2,700.7	(68.9)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 45.4 хувь буюу 1,226.4 сая төгрөг нь төсөвт байгууллагад, 53.4 хувь буюу 1,440.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит байгууллагуудад, 1.2 хувь буюу 33.6 сая төгрөг нь төрийн санд байна.

Төсөвт байгууллагууд дахь нийт авлагын 1,194.3 сая төгрөг буюу 97.4 хувийг хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага эзэлж байгаа бол орон нутгийн өмчит байгууллагуудын нийт авлагын 706.5 сая төгрөг буюу 49.0 хувийг “Дархан Ус суваг” ОНӨХК-ийн, 394.4 сая төгрөг буюу 27.4 хувийг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ЭМД-ын сангаас авах авлага эзэлж байна.

Тайлант онд орон нутгийн өмчит байгууллагуудын авлага 371.3 сая төгрөгөөр өсөхөд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ЭМД-ын сангаас авах авлага 203.7 сая төгрөгөөр, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын хөрөнгө оруулалтын гэрээт ажлын авлага 205.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.3. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 446.9 сая төгрөг болж, өмнөх оноос 371.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	75.7	446.9	371.2
Дүн	75.7	446.9	371.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8.2	95.0	86.8
ОНӨҮГ	67.5	351.9	284.4
Дүн	75.7	446.9	371.2

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэсэн 446.9 сая төгрөгийн 77.4 хувь буюу 345.9 сая төгрөг нь “Дархан Ус суваг” ОНӨХК-ийн, 19.4 хувь буюу 86.8 сая төгрөг нь Дархан сумын ЗДТГ-ын үлдэгдэл эзэлж байна.

“Дархан Ус суваг” ОНӨХК-д бүртгэсэн урьдчилж гарсан зардлын 48.5 сая төгрөг нь цэвэр усны үйлдвэр барих урьдчилгаа төлбөр, 261.8 сая төгрөг нь гадна фасад, нэг давхрын засварын урьдчилгаа, 28.1 сая төгрөг нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх төлбөр байна.

Дархан сумын ЗДТГ-ын албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн 86.8 сая төгрөгийн төлбөрийг оны эцэст шилжүүлснээс урьдчилж төлсөн зардал үүсжээ.

Аудитын илрүүлэлт:

- Дархан сумын ЗДТГ албан хаагчид шинжилгээнд хамрагдаагүй байхад 86.7 сая төгрөгийн гэрээний төлбөрийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн.

4.4. Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 3,789.8 сая төгрөг байснаас оны эцэст 4,630.7 сая төгрөг болж, 840.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	399.3	344.1	(55.2)
Хангамжийн материал	3,111.5	3,988.7	877.2
Биологийн хөрөнгө	20.0	20.0	00.0
Мал амьтад	259.0	277.9	18.9
Дүн	3,789.8	4,630.7	840.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,665.5	2,077.7	412.2
ОНӨҮГ	2,124.3	2,553.0	428.7
Дүн	3,789.8	4,630.7	840.9

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 55.1 хувийг ОНӨААТҮГ, 44.9 хувийг төсөвт байгууллагын үлдэгдэл эзэлж байна.

Төсөвт байгууллагын бараа материалын 412.2 сая төгрөгийн өсөлтөд дараах ажил гүйлгээнүүд голлон нөлөөлжээ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Зулзагын голын нарсан ойг тэлэх зорилгоор 169.6 сая төгрөгийн мод худалдан авч бүртгэсэн,
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнгээр Хонгор сумын Засаг даргын тамгын газарт 114.4 сая төгрөгийн, Шарын гол сумын Засаг даргын тамгын газарт 124.6 сая төгрөгийн, Орхон сумын Засаг даргын тамгын газарт 39.7 сая төгрөгийн бараа материал тус тус нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ЗДТГ 19.8 сая төгрөгийн шагналын тэмдгийг бэлэн бүтээгдэхүүний дансанд бүртгэсэн.
- Хонгор сумын ЗДТГ мал үржүүлгийн эхо аппаратыг 12.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.
- “Хонгор хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь үнэ төлбөргүй хүлээн авсан 109.5 сая төгрөгийн бараа материалыг орлого үр дүнгийн тайланд тайлагнасан.

4.5. Нөөцийн бараа

Нөөцийн бараа материалын эхний үлдэгдэл 155.4 сая төгрөг байснаас оны эцэст 148.0 сая төгрөг болж, 7.4 сая төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 7. Нөөцийн барааны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	141.2	148.3	7.1
Шатахууны нөөц	0.3	0.3	0.0
Буудайн нөөц	6.5	20.5	14.0
Дүн	148.0	169.1	21.1

Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	148.0	169.1	21.1
Дүн	148.0	169.1	21.1

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэлд гамшгийн хор уршгаас сэргийлэх зорилгоор аймаг, сумдын ЗДТГ-т нөөцийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс, тэжээл, шатахууны нөөц бүртгэлтэй байна.

Аймаг, сумдын ЗДТГ тайлант онд 123.0 сая төгрөгийн нөөц бүрдүүлж, эхний үлдэгдлээс 101.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

Нөөцийн бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.6. Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,360.1 сая байснаас оны эцэст 271.5 сая төгрөг болж, 8,088.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	8,360.1	271.5	(8,088.6)
Дүн	8,360.1	271.5	(8,088.6)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2,354.6	271.5	(2,083.1)
ОНӨҮГ	6,005.5	0.0	(6,005.5)
Дүн	8,360.1	271.5	(8,088.6)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4²-т заасны дагуу бүртгэсэн төсвийн жил дамжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлууд тайлант онд дууссанаар төсөвт байгууллага дахь бусад эргэлтийн хөрөнгийн дүн 2,083.1 сая төгрөгөөр буурчээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн бууралт нь Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл” дууссанаар бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.7. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 283,121.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	43,762.6	66,287.6	2,2525.0
Авто тээврийн хэрэгсэл	6,177.7	21,569.7	15,392.0
Машин тоног төхөөрөмж	7,968.3	21,955.0	13,986.7
Тавилга эд хогшил	924.8	1,925.4	1,000.6
Зам гүүрийн байгууламж	83,010.4	82,177.7	(832.7)

² Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Бусад үндсэн хөрөнгө	22,787.4	36,008.0	13,220.6
Дуусаагүй барилга байгууламж	79.5	79.5	0.0
Номын фонд	20.4	22.2	1.8
Программ хангамж	117.0	118.6	1.6
Бусад биет бус хөрөнгө	48,237.6	52,976.2	4,738.6
Биологийн хөрөнгө	1.6	1.6	0.0
Дүн	213,087.3	283,121.5	70,034.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	42,723.1	60,941.6	18,218.5
ОНӨҮГ	170,364.2	222,179.9	51,815.7
Дүн	213,087.3	283,121.5	70,034.2

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 60,941.6 сая төгрөг буюу 21.5 хувь нь төсөвт байгууллагад, 222,179.9 сая төгрөг буюу 78.5 хувь нь орон нутгийн өмчит байгууллагад бүртгэлтэй байгаа бөгөөд 81.2 хувийг биет хөрөнгө, 18.8 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн өсөлтийн гол шалтгаан нь “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн хүрээнд бий болсон насос станцын барилга, захиргааны барилга, аеротенк, агааржуулах станц, хоёрдогч тунгаагуур, био цөөрөм лаг эрдэсжүүлэх талбай, гадна шугам хоолой зэрэг 39,559.2 сая төгрөгийн хөрөнгийг, мөн ус түгээх цэг, ус түгээх, шахах, өргөх байгууламж, амралтын зориулалттай эзэмших эрх бүхий 2,103.0 сая төгрөгийн 27 газрыг “Дархан Ус суваг” ОНӨХК-д бүртгэсэн, УТХО-аар санхүүжсэн 12,817.2 сая төгрөгийн өртөгтэй 20 ширхэг автобусыг аймгийн ЗДТГ-т бүртгэсэн, ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн 16,298.2 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайн тоног төхөөрөмжийг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-т бүртгэсэнтэй тус тус холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ЗДТГ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 62.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй.
- Худалдан авах ажиллагааны газар 9.1 сая төгрөгийн элэгдлийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй.
- Орон нутгийн өмчийн газар үндсэн хөрөнгийн тодруулга тайланд Цагдаагийн газраас шилжүүлэн авсан 13.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнасан.
- Дархан сумын ЗДТГ 6.3 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу бүртгэсэн, 1,046.2 сая төгрөг бүхий газрыг орлогод авахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн, аймгийн ОНХС, ОНХО-аар бий болсон 20.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- Аймгийн ИТХ ашиглалтын хугацаа дууссан хөрөнгөд элэгдэл тооцсон.
- “Госхот” ӨЭМТ нь 12.3 сая төгрөгийн контейнерийг барилга байгууламжид бүртгэсэн,
- “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь 143.3 сая төгрөгийн шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 2.7 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцоолсон,
- “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь 38,943.7 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй бүртгэсэн,
- “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ нь 5,714.5 сая төгрөгийн эздийн өмчийн дүнг зөрүүтэй тусгасан
- Хонгор сумын ЗДТГ 1,162.3 сая төгрөгийн сумын төвийн гэрэлтүүлэг, авто замыг ангилал буруу бүртгэсэн, хөрөнгийн гарз 7.4 сая төгрөгийг биет бус хөрөнгө худалдан авсан зардалд бүртгэсэн.
- Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үндсэн хөрөнгийн дансанд 750.0 мянган төгрөгийн дахин үнэлсэн программ хангамжийг орлогод аваагүй.
- Шарын гол сумын ЗДТГ 385.1 сая төгрөгийн газрыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй.
- Шарын гол сумын ИТХ 3.0 сая төгрөгийн дахин үнэлсэн хөрөнгийг бусад орлогоор бүртгэсэн.

4.8. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 81,282.0 сая төгрөг байснаас оны эцэст 64,798.2 сая төгрөг болж, 16,483.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр)
			Өсөлт (+), Бууралт (-)
<u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u>	81,282.0	53,076.6	(28,205.4)
Богино хугацаат зээлийн өглөг	51,890.4	31,086.6	(20,803.8)
Ажилчидтай холбогдсон өглөг	115.7	138.4	22.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.8	0.0	(0.8)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	27,562.1	20,227.9	(7,334.2)
Бусад өглөг	1,703.0	1,612.4	(90.6)
Урьдчилж орсон орлого	10.0	11.3	1.3
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>	0.0	11,703.7	11,703.7
Бусад урт хугацаат өр төлбөр /ОНӨҮГ/	0.0	11,703.7	11,703.7
Нийт дүн	81,282.0	64,780.3	(16,501.7)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төрийн сан	51,890.4	31,086.6	(20,803.8)
Төсөл/сан	15.0	71.2	56.2
Төсөвт байгууллага	28,307.1	20,776.1	(7,531.0)
ОНӨҮГ	1,069.5	12,846.4	11,776.9
Дүн	81,282.0	64,780.3	(16,501.7)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сан дахь богино хугацаат өр төлбөр нь Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хоорондын Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн зээлийн төлбөрт 21,850.0 сая төгрөгийг төлснөөр буурчээ.

“Найрамдал-Дархан хотын нийгэм, эдийн засгийн шинэлэг, тэгш хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжин Европын холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх төсөл”-өөс харилцагч байгууллагад санхүүжилт дутуу олгосноос үүссэн төсөл сан дахь өр төлбөрийн эхний үлдэгдэл 15.0 сая төгрөгийг тайлант онд төлж барагдуулсан байна. Харин сумдын байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа дансанд төвлөрсөн 71.2 сая төгрөгийг эцсийн үлдэгдлээр тайлагнажээ.

Өмнөх онд орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан чанарын болон гүйцэтгэлийн баталгааны төлбөрийн 8,187.3 сая төгрөгийн бууралт нь төсөвт байгууллагын өр төлбөрийн бууралтад голлон нөлөөлсөн байна.

“Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл” нь 2016 оны 3 дугаар сард эхлэн, тайлант онд дууссанаар 39,559.2 сая төгрөгийн хөрөнгийг “Дархан Ус суваг” ОНӨХК-д бүртгэсэн ба үүнээс 27,855.5 сая төгрөгийг Сангийн яам буюу Засгийн газарт төлж барагдуулан, үлдэгдэл 11,703.7 сая төгрөгийг ашиглагч байгууллагад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн байна.

Нийт өр төлбөрөөс хугацаа хэтэрсэн болон тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ 2.5 сая төгрөгийн, Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ нь нь 2.6 сая төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- “Хонгор хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь хог тээврийн 8.0 сая төгрөгийн орлогыг өглөг үүсгэлгүйгээр зарцуулсан.

4.9. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 202,145.7 сая төгрөг байснаас тайлант онд 73,714.7 сая төгрөгөөр өсөж, оны эцэст 275,860.4 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр) Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	22,834.9	18,931.8	(3,903.1)
Өмч /ТӨҮГ/	23,187.4	5,242.7	(17,944.7)
Эздийн өмчийн бусад хэсэг	168,853.2	219,215.7	50,362.5
Хуримтлагдсан үр дүн	(46,782.6)	(1,582.6)	45,200.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,052.8	34,052.8	0.0
Нийт дүн	202,145.7	275,860.4	73,714.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төрийн сан	(27,069.3)	14,946.7	42,016.0
Төсөл/сан	1,898.7	1,766.4	(132.3)
Төсөвт байгууллага	53,363.7	70,442.9	17,079.2
ОНӨҮГ	173,952.6	188,704.4	14,751.8
Нийт дүн	202,145.7	275,860.4	73,714.7

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 18,931.8 сая төгрөг болж, 3,903.1 сая төгрөгөөр буурсан нь сумдын ЗДТГ-уудад 1,331.0 сая төгрөгийн газрыг бүртгэлд авснаар нэмэгдэж, орон нутгийн өмчит 7 хуулийн этгээдүүдийн 5,234.2 сая төгрөгийн өмчийг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу “өмч”-ийн дансанд бүртгүүлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өмчийн дансны 17,944.7 сая төгрөгийн бууралт нь “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын 22,471.3 сая төгрөгийн өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй байсан тул “эздийн өмчийн бусад хэсэг” данс руу залруулснаас голлон шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны 50,362.5 сая төгрөгийн өсөлт нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө хүлээн авсан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлснээр 27,408.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, 22,953.6 сая төгрөгийн өмчийн ангиллыг залруулан бүртгэсэнтэй тус тус холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн данс тайлант үеийн 45,225.4 сая төгрөгийн ашиг, “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 70.6 сая төгрөгийн залруулгаар нэмэгдэж, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2024 онд зарласан 94.1 сая төгрөгийн ногдол ашиг, 3 байгууллагын 1.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр буурчээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт ороогүй байна.

Аудитын илрүүлэлт:

- “Мэдээлэл технологийн алба” ОНӨААТҮГ 12.9 сая төгрөгийн, “Дархан дахин төлөвлөлт” ОНӨААТҮГ 60.2 сая төгрөгийн, “ХАА-н техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ 409.2 сая төгрөгийн, “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ 22,471.3 сая төгрөгийн, “Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ 111.6 сая төгрөгийн, “Эмтнаран” ОНӨААТҮГ 945.3 сая төгрөгийн, “Тулга сувилал” ОНӨААТҮГ 55.2 сая төгрөгийн, “Хонгор хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ 792.9 сая өмчийн дүнг тус тус ангилал зөрүүлэн бүртгэсэн.

4.10. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 20 орон нутгийн өмчит хуулийн этгээд хамрагдаж, бүх байгууллагад санал дүгнэлт гаргаснаас бүгд өөрчлөлтгүй дүгнэлт авчээ.

Аудитаар нийт 68,971.5 сая төгрөгийн 42 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 68,931.5 сая төгрөгийн 19 алдааг залруулж, 5.7 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлэн, 34.3 сая төгрөгийн 10 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Мөн холбогдох хууль, тогтоомжийн зөрчсөн нийцлийн асуудлаар 7.5 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн байна.

4.11. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар нийт 4,112.5 сая төгрөгийн алдаа³ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- “Дархан Ус суваг” ОНӨХК-ийн 3,384.4 сая төгрөгийн, “Мэдээлэл технологийн алба” ОНӨААТҮГ-ын 1.0 сая төгрөгийн, “Үйлдвэр технологийн парк” ОНӨААТҮГ-ын 10.5 сая төгрөгийн, Ахмадын хорооны 716.6 сая төгрөгийн өмчийн дүнг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС35 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-тай тус тус нийцэхгүй, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу зохих дансанд бүртгүүлж, залруулав.

4.12. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны аудитаар авлага, бараа материалын данстай холбоотой 2 зөвлөмж өгсөн ба аудитын шийдвэрийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 1-10/645 тоот албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлснийг тайлагналын дараах үе шатны хяналтаар шалгахад:

- ТЕЗ-ийн төрийн сан дахь 33.6 сая төгрөгийн авлагын анхан шатны баримтыг цуглуулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа тул биелэлтийг 100.0 хувиар,

- Өгсөн зөвлөмжийн дагуу Хүүхдийн зуслангийн бараа материалын дансанд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийн шинжтэй 9 нэр төрлийн 88.8 сая төгрөгийн хөрөнгийг 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулан бүртгэсэн тул биелэлтийг 100.0 хувиар тус тус тооцов.

Хүснэгт 12. Зөвлөмжийн хэрэгжилт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	122.4	2	122.4	100.0
Нийт дүн	2	122.4	2	122.4	100.0

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

4.13. ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитыг хэрэгжүүлж байна.

Тус алба нь 2024 онд 26 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 31 байгууллагад дотоод аудит, 7 байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт, нийт 64 хяналт шалгалт хийж, нийт нийт 2,275.3 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Үүнээс 261.1 сая төгрөгийн зөрчилд 166 төлбөрийн акт, 1,646.8 сая төгрөгийн зөрчилд 122 албан шаардлага, 367.3 сая төгрөгийн зөрчилд 242 зөвлөмж хүргүүлснээс 2,100.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулан акт, албан шаардлагын биелэлтийг 94.6-95.4 хувиар хангуулан ажиллажээ.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.5⁴-д заасны дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийг шалган, хуулийн хэрэгжилтийг 100.0 хувьтай үнэлж, чанарын үзүүлэлтийг 98.8 хувьтай гэж дүгнэсэн байна. Түүнчлэн тус алба нь шилэн дансны цахим системийн дотоод хяналтын мэдээллийг улирал тутам <https://sankhuu.audit.da.gov.mn> байгууллагын цахим хуудас, Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба фэйсбүүк хуудас, ШИЛЭН ДАНС СХДАА группээр мэдээлж, төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 74 нягтлан бодогчид сургалт зохион байгуулсан байна.

4.14. ШИЛЭН ДАНС

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дархан-Уул аймгийн ТЕЗ нь тайлант онд шилэн дансны цахим хуудаг оруулбал зохих мэдээллээс 111,896.3 сая төгрөгийн батлагдсан төсөв, 154,921.9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тайланг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Иймд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаг мэдээлэл байршуулсан байдлыг 100 хувиар, хугацааны мөрдөлтийг 84.6 хувиар тус тус дүгнэлээ.

Харин ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас 15 байгууллага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг оруулаагүй, хугацаа хоцроосон нийт 11,632.9 сая төгрөгийн зөрчил илэрчээ. Үүнээс 2 байгууллагын 80.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 13 байгууллагын 11,552.6 сая төгрөгийн зөрчилд цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн байна.

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

5. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар нийт 89,124.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 88,473.6 сая төгрөгийн 57 алдааг залруулж, 26.5 сая төгрөгийн 23 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.7 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 610.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 37 зөвлөмжийг хүргүүлж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлжээ.

Залруулагдаагүй 650.5 сая төгрөгийн зөрчил (шилэн данстай холбоотой 278,451.1 сая төгрөгийн зөрчлийг хассан) нь тогтоосон 3,410.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Тайлангийн 4.14 дэх хэсэгт өгсөн шилэн данстай холбоотой зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁵-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

№	Төсөв захирагчийн ангилал	Нэгтгэсэн байгууллагын тоо	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийх	Аудитад хамрагдаагүй	Гаргасан дүгнэлт			
					Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан
1	ТЕЗ	1	-	-	1	-	-	-
2	ТТЗ	4	-	-	4	-	-	-
3	ТШЗ	19	-	-	19	-	-	-
4	ОНТС	10	7	-	3	-	-	-
5	Төсөл сан	1	-	-	1	-	-	-
6	ОНӨААН	20	-	-	20	-	-	-
	Бүгд дүн	55	7	-	48	-	-	-

⁵ Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		3	4	5	6	7	8	9	10	11	12
A	2										
1	Дархан сумын ЗДТГ	6	1,514,993.0	3	375,723.8	3	1,139,269.2	6	1,514,993.0	-	-
2	Аймгийн ИТХ	1	130.1	1	130.1	-	-	1	130.1	-	-
3	Аймгийн ЗДТГ	3	3,254,832.7	1	62,704.0	2	3,192,128.7	3	3,254,832.7	-	-
4	Захирагчийн алба	3	114,382.8	1	67,864.1	2	46,518.7	3	114,382.8	-	-
5	Худалдан авах ажиллагааны газар	3	70,278.1	-	-	3	70,278.1	3	70,278.1	-	-
6	Орон нутгийн өмчийн газар	1	13,500.0	-	-	1	13,500.0	1	13,500.0	-	-
7	Хонгор сумын ЗДТГ	3	1,182,317.9	-	-	3	1,182,317.9	3	1,182,317.9	-	-
8	Орхон сумын ХХС	1	750.0	1	750.0	-	-	1	750.0	-	-
9	Шарын гол сумын ИТХ	2	3,077.3	-	-	2	3,077.3	2	3,077.3	-	-
10	Шарын гол сумын ЗДТГ	2	398,363.5	-	-	2	398,363.5	2	398,363.5	-	-
	Дүн	25	6,552,625.4	7	507,172.0	18	6,045,453.4	25	6,552,625.4	-	-
1	Орхон сумын ТТЗ	5	229,302.8	1	13,263.0	4	216,039.8	5	229,302.8	-	-
2	Дархан сумын ТТЗ	2	5,896,895.5	-	-	2	5,896,895.5	2	5,896,895.5	-	-
3	Хонгор сумын ТТЗ	3	2,670,552.7	-	-	3	2,670,552.7	3	2,670,552.7	-	-
4	Шарын гол сумын ТТЗ	2	80,187.2	-	-	2	80,187.2	2	80,187.2	-	-
	Дүн	12	8,876,938.2	1	13,263.0	11	8,863,675.2	12	8,876,938.2	-	-
1	Гос хот ЗБН	1	12,300.0	-	-	1	12,300.0	1	12,300.0	-	-
2	Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ	1	12,879.0	-	-	1	12,879.0	1	12,879.0	-	-
3	Орхон Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	4	126,506.5	2	110,100.0	2	16,406.5	4	126,506.5	-	-
4	ДОНЗТ ОНӨААТҮГ	1	22,471,304.0	1	22,471,304.0	-	-	1	22,471,304.0	-	-
5	ДХББЗГ ОНӨААТҮГ	1	2,190.8	-	-	1	2,190.8	1	2,190.8	-	-
6	ДХСАХ ОНӨААТҮГ	2	144,572.7	1	143,299.0	1	1,273.7	2	144,572.7	-	-
7	ДХТҮГ ОНӨААТҮГ	1	38,943,745.1	1	38,943,745.1	-	-	1	38,943,745.1	-	-
8	Дархан хотын хог тээвэр ОНӨААТҮГ	1	5,714,493.5	1	5,714,493.5	-	-	1	5,714,493.5	-	-
9	Хонгор хот тохижилт ОНӨААТҮГ	4	1,030,837.6	1	792,872.7	3	237,964.9	4	1,030,837.6	-	-
10	Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ	1	60,224.8	1	60,224.8	-	-	1	60,224.8	-	-
11	ХАА-н техник дундын төв ОНӨААТҮГ	1	409,207.6	1	409,207.6	-	-	1	409,207.6	-	-
12	Тулга сувилал ОНӨААТҮГ	1	3,276.8	1	3,276.8	-	-	1	3,276.8	-	-
	Дүн	19	68,931,538.4	10	68,648,523.5	9	283,014.9	19	68,931,538.4	-	-
1	Аймгийн нэгтгэсэн тайлан	1	4,112,535.1	-	-	1	4,112,535.1	1	4,112,535.1	-	-
	Бүгд дүн	57	88,473,637.1	18	69,168,958.5	39	19,304,678.6	57	88,473,637.1	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(Мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Үүнээс																							
		Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж				Хариуцлага тооцуулах албан тушаалтан				Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
A	1	2	4	3	5	6	7	8	9	10	11	12	13	14											
1	Дархан сумын ИТХ	1	1,960.0	-	-	-	1	1,960.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
2	Дархан сумын ХХС	1	1,599.9	1	1,599.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
3	Аймгийн ИТХ	3	14,925.8	1	255.0	-	-	-	2	14,670.8	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
4	Аймгийн ЗДТГ	6	15,640.5	4	11,290.1	1	4,350.4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
5	Захирагчийн ажлын алба	1	1,839.7	1	1,839.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
6	Ахмадын хөгжлийн төв	1	550.0	-	-	-	-	-	1	550.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
7	Худалдан авах ажиллагааны газар	1	120.0	1	120.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
8	Сум дундын Ойн анги	1	666.7	-	-	-	-	-	1	666.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
9	Орон нутгийн өмчийн газар	1	111.7	-	-	-	-	-	1	111.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
10	Хонгор сумын ЗДТГ	3	7,632.1	2	4,658.1	1	2,974.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
11	Орхон сумын ЗДТГ	2	3,751.5	1	1,070.7	-	-	-	1	2,680.8	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
12	Шарын гол сумын ЗДТГ	1	4,394.0	-	-	-	1	4,394.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
13	Шарын гол сумын ИТХ	1	3,021.0	-	-	-	-	-	1	3,021.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
	Дүн	23	56,212.9	11	20,833.5	4	13,678.4	7	21,701.0	1	31,500.0	298,620.0	27,000.0	35,423.4	392,543.4	4	3,080.0	4,591.9	10,040.3	9,940.0	2,613.5	-			
1	Орхон сумын ТТЗ	1	31,500.0	-	-	-	-	-	1	31,500.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
2	Дархан сумын ТТЗ	1	298,620.0	-	-	-	-	-	1	298,620.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
3	Хонгор сумын ТТЗ	1	27,000.0	-	-	-	-	-	1	27,000.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
4	Шарын гол сумын ТТЗ	1	35,423.4	-	-	-	-	-	1	35,423.4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
	Дүн	4	392,543.4	-	-	-	-	-	4	392,543.4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
1	Амин холбоо ЗБН	1	334.3	1	334.3	-	-	-	0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
2	Дархан Ус суваг ОНӨХК	1	4,031.5	-	-	-	-	-	1	4,031.5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
3	Орхон Тохжилт үйлчилгээ ОНӨААТҮГ	2	3,275.0	1	195.0	-	-	-	1	3,080.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
4	Эмт наран ОНӨААТҮГ	1	4,591.9	-	-	-	-	-	1	4,591.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
5	ДХСАХ ОНӨААТҮГ	5	10,651.3	1	611.0	1	1,040.3	-	3	10,040.3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
6	ДХТҮГ ОНӨААТҮГ	2	10,260.0	1	320.0	-	-	-	1	9,940.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
7	Дархан хотын хог тээвэр	2	3,007.3	1	393.8	-	-	-	1	2,613.5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
8	ХАА-н техник үйлчилгээний дундын төв	1	113.6	1	113.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
9	ДХББЗГазар ОНӨААТҮГ	2	-	-	-	-	-	-	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			
10	Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ	2	1,345.6	2	1,345.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-			

Дархан-Уул аймгийн ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

11	Хонгор хот тохижилт ОНӨААТҮГ	1	487.6	1	487.6	-	-	-	-	-	-	-	-
12	Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ	1	409.6	1	409.6	-	-	-	-	-	-	-	-
13	Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ	1	539.2	1	539.2	-	-	-	-	-	-	-	-
14	Тулга сувилал ОНӨААТҮГ	1	909.1	1	909.1	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	23	39,956.0	12	5,658.8	1	10	34,297.2	-	-	-	-	-
	Бүгд дүн	50	488,712.3	23	26,492.3	5	13,678.4	448,541.6	1	-	-	-	-

6.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил			Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>										
1	Дархан сумын ЗДТГ	1	1,422,109.8	-	-	-	-	1	1,422,109.8	
2	Аймгийн ИТХ	1	2,682,193.3	-	-	-	-	1	2,682,193.3	
3	Аймгийн ЗДТГ	1	1,799,555.3	-	-	-	-	1	1,799,555.3	
4	Захирагчийн ажлын алба	1	6,188.6	-	-	-	-	1	6,188.6	
5	Халамжийн сан	1	124,100.0	-	-	-	-	1	124,100.0	
6	Худалдан авах ажиллагааны газар	1	198,227.2	-	-	-	-	1	198,227.2	
7	Ахмадын хөгжлийн төв	1	-	-	-	-	-	1	-	
8	Орон нутгийн өмчийн газар	1	-	-	-	-	-	1	-	
9	Дархан сумын ИТХ	1	-	-	-	-	-	1	-	
10	Хонгор сумын ЗДТГ	1	2,614,510.5	-	-	-	-	1	2,614,510.5	
11	Орхон сумын ЗДТГ	1	16,004.8	-	-	-	-	1	16,004.8	
12	Шарын гол сумын ЗДТГ	1	144,700.6	-	-	-	-	1	144,700.6	
13	Дархан хотын соёл амралтын хүрээлэн	1	-	-	-	1	-	-	-	
14	Орхон Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	1	80,317.7	-	-	1	80,317.7	-	-	
15	Эмт наран ОНӨААТҮГ	1	2,545,000.0	-	-	-	-	1	2,545,000.0	
16	Аймгийн ТЭЗ	1	266,818,182.5	-	-	-	-	1	266,818,182.5	
	Дүн	16	278,451,090.3	-	-	2	80,317.7	14	278,370,772.6	
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>										
1	Аймгийн ИТХ	1	-	-	-	-	-	1	-	
2	Аймгийн ЗДТГ	1	65,000.0	-	-	-	-	1	65,000.0	
3	Хүүхдийн зуслан	1	89,223.4	-	-	-	-	1	89,223.4	
4	БОАЖГ	1	-	-	-	-	-	1	-	
5	Захирагчийн ажлын алба	1	-	-	-	-	-	1	-	
6	Ахмадын хөгжлийн төв	1	-	-	-	-	-	1	-	
7	Орон нутгийн өмчийн газар	1	-	-	-	-	-	1	-	
8	Дархан сумын ХХС	1	-	-	-	-	-	1	-	
9	Дархан сумын ИТХ	1	-	-	-	-	-	1	-	
10	Хонгор сумын ИТХ	1	-	-	-	-	-	1	-	
11	Шарын гол сумын ИТХ	1	-	-	-	-	-	1	-	
12	МЭДС ТӨБ ЗБН	1	-	-	-	-	-	1	-	
13	Гэрэлтэй ЗБН	1	-	-	-	-	-	1	-	
14	Ахмадын хороо	2	7,500.0	-	-	-	-	2	7,500.0	
15	Эмт наран ОНӨААТҮГ	1	-	-	-	-	-	1	-	
	Дүн	16	161,723.4	-	-	2	-	16	161,723.4	
	Нийт дүн	32	278,612,813.7	-	-	2	80,317.7	30	278,532,496.0	